

ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ СУДЛАЛЫН ЗАЙЛШГҮЙ БОЛОХ НЬ

Ш.Эгшиг¹

Товч агуулга: Утга зохиолын шүүмжлэлийн нэг төрөлд багтдаг орчуулгын шүүмж нь хэрэглээний орчуулгазүйн нэг судлахуун юм. Иймээс орчуулгын шүүмжийг хосолмол шинжтэй шүүмж гэж үзэж болно. Орчуулгын шүүмж бол орчуулгын онол практикийг уялдуулан холбож, орчуулгын чанарыг үнэлэх хэрэгсэл болж байдаг. Өнөөгийн утга зохиол, орчуулгазүйн хөгжлийн үүднээс орчуулгын шүүмжийг санал шүүмж төдийгөөр ойлгох бус илүү өргөн утгаар ойлгох хэрэгтэй болсныг дэлхий дахины судлаачдын сүүлийн үеийн бүтээлээс бид тусган авч байгаа юм.

Түлхүүр үг: орчуулгын шүүмж, шүүмж судлал, орчуулгын чанар, орчуулгын хэм хэмжээ, орчуулах эх, орчуулга

Өнгөрсөн зуунд Монголын шинэ цагийн нэгэн үеийн орчуулагчид төрөн гарч, өрнө дорны сонгодог уран зохиолоос олон бүтээл орчуулан монгол түмнийг оюуны ундаагаар ундалж, олон соёлын талаархи танин мэдэхүйнх нь хүрээг тэлжээ. Чингээд эдгээр олон орчуулгын бүтээлтэй зэрэгцэн орчуулгын шүүмж судлал ч мөн сууриа тавьж, энэ чиглэлийн бүтээл туурвил ч нэлээд хэмжээгээр нийтлэгдэн гарч эхэлсэн байдаг. Тийн шүүмжлэгчдийн индэр нь ерөнхийдөө тодорхой нэр бүхий төвийн хэвлэл, “Уран үгсийн чуулган”, “Цог” сэтгүүл”, “Орчуулах эрдэм” зэрэг уран зохиолын судлал шинжлэл, нийтлэлийн сэтгүүл байжээ.

Орчуулгын шүүмж судлал хэмээх ухаан өнөө цагт Монголын нийгэмд мөн л зайлшгүй байх зүй ёсны нэгэн ухаан болно. Орчуулгын шүүмж судлал хэмээхийн тухайтад, эхлээд уг ухааны талаар хэрхэн тодорхойлох талаар товч өгүүлэхийг хүснэ. Аливаа ухаан бол судлах оногдохуунтай, судлаачтай, судалгааны арга, аргазүй, зорилготой байдаг. Орчуулгын шүүмж бол утга зохиолын шүүмжлэлийн доторхи олон шүүмжийн нэг юм. Тухайлбал, утга зохиолын шүүмжлэлд шүүмж, шүүмж өгүүлэл, нэг сэдэвт зохиол, уран бүтээлчийн хөрөг гэх төрлүүд багтана. Эдгээр нь дотроо мөн тус тусын шүүмжийг агуулна. Утга зохиолын шүүмжлэл хэмээх ухааны “шүүмж” дотор орчуулгын шүүмж, шүүмжлэлийн шүүмж, хариу шүүмж, шог шүүмж багтаж байна. Тэгэхээр орчуулгын шүүмж бол утга зохиол хэмээх ухааны нэг л эд эс болох нь. Орчуулгын шүүмжийг нэг талаар утга зохиолын онолын үүднээс тайлбарлаж болохын дээр, мөн орчуулгазүйн үүднээс ч оновчтой тодорхойлж болно. Иймээс орчуулгын шүүмж судлал нь хосолмол шинжийг агуулсан ухааныг судлах нэлээд төвөгтэй судлал болж байна.

¹ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим, дэд профессор, доктор

Утга зохиолын шүүмж судлалын чиглэлээр С.Буяннэмэх² Ши.Аюуш, Ц.Хасбаатар, Ц.Мөнх, Ч.Билигсайхан, Д.Галбаатар, С.Энхбаяр, Х.Чойдогжамц, Г.Аюурзана зэрэг манай үе үеийн эрдэмтэд, ялангуяа утга зохиол судлаач нар бүгд л энэ сэдвийг хөндөж иржээ. Утга зохиолын олон салбар, төрөл жанрын чиглэлээр дагнан шүүмж хийдэг хүн салбар салбартаа тийм ч олон биш. Тухайлбал, кино шүүмжлэгч гэдэг мэргэжил байдаг ч, манайд кино урлагийн салбарыг дорвитой судлаад, мэргэжлийн төвшинд үнэлэлт дүгнэлт өгдөг хүн ховор байгаа³ талаар салбарынхан хэлдэг. Утга зохиолын аль нэг чиглэлийн шүүмжлэгч хүн бол тухайн салбарын мэргэжлийн төвшний мэдлэгтэй мэргэшсэн шүүмжлэгч байх хэрэгтэй. Шүүмжийг судалдаг шүүмж судлаач нар бас гарч ирэх ёстой. Ингэж байж шүүмж судлал нь хөгжинө. Өнөө цагийн утга зохиолын шүүмж судлалын судлаачдын нэг гол төлөөлөгч бол манай нэрт дуун хөрвүүлэгч Ц.Магсар юм. Түүний үнэт зүйлд тулгуурласан гоо зүйн үзлээр уран сайхны бүтээлийг үнэлэх үнэлгээний хандлагаар хийсэн Монголын утга зохиолын шүүмжлэлийн судалгаа⁴ нь эдүгээ өнгөрсөн зууны 90-ээд оноос хойш бараг хаягдаж гээгдсэн утга зохиолын шүүмжлэл судлалын хоосон орон зайг нөхсөн бүтээл болсон юм. Энэ судалгааг хийхэд судлаачийн гадаад хэлний мэдлэг, орчуулагчийн билгүүн авьяас нь ч нөлөөлсөн гэж үзүүштэй. Судалгаандаа түүхэн уламжлалт шүүмжийн хэлбэр, мөн чанарыг эх бүтээлүүд дотроос илрүүлэн олж, энэ үндсэн дээр орчин үеийн утга зохиолын шүүмжлэлийн төрөл ангиллыг хийсэн явдал бол нэгэн их чухал ажил болж үндсэндээ Монголын утга зохиолын шүүмжлэлийг шинэ өндөр төвшинд гаргажээ. Ц.Магсарын утга зохиолын шүүмжлэлийн ангиллыг дурдвал,

1. Шүүмж
 - Шүүмж
 - Захидал
 - Тэмдэглэл
2. Шүүмжлэлийн өгүүлэл
 - Онолын өгүүлэл
 - Маргааны өгүүлэл
 - Тойм
 - Бодол эргэцүүлэл
3. Нэг сэдэвт зохиол
4. Уран бүтээлчийн хөрөг
 - Хөрөг

² С.Буяннэмэх “Манай зохиолч нөхдөөс өгүүлэх нь: Манай улсад шинэ зохиолууд олирон гарч байна. Гагцхүү түүний сайн муу чанар ба найруулгын талаар онц болж уу, аль эс бөгөөс дутмаг болж буюу, тийм болсон нь юун дээр байна, утгын талаар тохироогүй зүйл байна уу, ер хэрхэн ямар маягтай болж буй, та нөхдийн унших болон ард нийтийн уншихад хэр тохирсон тохироогүй газар байна, эдгээрийг хэлж өгөх зохиолчийн нөхөд юунд үл гарна...” хэмээн бичиж байжээ. Түүвэр зохиол, Улаанбаатар, 1968

³ (<http://www.read.mn/a/2259>).

⁴ Ц.Магсар, I. XX зууны утга зохиолын шүүмжлэлд төрөл зүйл бүрэлдсэн байдал, XX зууны Монголын утга зохиолын шүүмжлэл, Улаанбаатар, 2009, Бит пресс, 16-51-р тал.

- Намтар зохиол
- Найруулал
- Ойн өгүүлэл эдгээр болно.

Утга зохиолын шүүмжлэлийн ангилалд багтах орчуулгын шүүмж нь утга зохиолын шүүмжлэл судлалын биеэ даасан оногдохуун гэж үзэж болно. Манай орчуулгын судлаачдын сүүлийн үед жагсаасан орчуулгын судалгааны бүтээлийн номзүйд⁵ үндэслэн бяцхан тооцоо хийж үзье. Уг номзүйд Монголын орчуулгын судлалын өнгөрсөн зууны 30-аад оноос өнөөг хүртэлх бүтээлийг бүрэн бус ч гэсэн ерөнхийд нь цуглуулж жагсаажээ. Нийт бүтээлийн ойролцоогоор 20% нь орчуулгын шүүмж эзэлж байна. Орчуулгын шүүмж дотроо сүүлийн 90 жилийн хугацаанд өнгөрсөн зууны 60, 70, 80-аад оныг хамарсан 30 гаруй жилд нийт орчуулгын шүүмжийн 64% нь хамаарагдаж байх юм. Чингэхээр орчуулгын шүүмж нэгэн үе нэлээд ихсэх хандлагатай байснаа, өнгөрсөн зууны 90-ээд оноос эрс саарчээ. Гэхдээ энд бид сүүлд өгүүлэх “санал шүүмж”-ийн түвшинд хийсэн тоон харьцуулал гэдгийг тодотгох ёстой.

Орчуулгын судлал 1959 оноос шинжлэх ухааны онолын үндэстэй болон хөгжиж орчин цагийн орчуулгазүйн хөгжлийн гол чиглэлээ барин хөгжсөөр байгаа билээ. Орчуулгазүйн судлачууны бүтцийг 1972 онд Жеймс Холмс гаргахдаа, хэрэглээний орчуулгазүйд орчуулгын шүүмжийг багтана⁶ гэдгийг тогтоож өгсөн. Өнөөгийн дэлхий дахины орчуулгын судалгаанд хэрэглээний орчуулгазүйн гурван том салбарын нэг болох орчуулгын шүүмж өөрөө мөн гурван үндсэн бүрэлдэхүүнтэйгээр хөгжиж байна. Энэ гурван бүрэлдэхүүнд орчуулгыг ариутган шүүх/хэвлэх үйл явц, чанарын үнэлгээ, санал шүүмж багтана. Үүнээс харахад, бидний толгойд тогтсон хэвшмэл ойлголтоор орчуулгын шүүмж гэдэг бол харьцангуй явцуу ойлголт байжээ хэмээн үзэхээр байгаа юм. Өөрөөр хэлбэл, бид орчуулгын шүүмж гэхээр хэн нэгэн этгээдийн хийсэн орчуулгын сайн болсныг шагшин сайшаах, эсвэл, алдаатай орчуулга, буруу оноосон үг хэллэгийг нь бүртгэн шүүмжлэх, тэдгээр алдаа, үгийн буруу оноолт нь нийгэм, соёлд хэрхэн хор уршиг тарих тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр бичиж нийтлэх, хэлэлцүүлэг өрнүүлэхийг хэлнэ гэж ойлгосоор иржээ. Чингэтэл, дэлхий дахинд үүнийг арай өргөн хүрээгээр харж, анхнаасаа орчуулгын чанартай зөв оновчтой байх тэр замыг нь засч өгөх ухааныг орчуулгын шүүмж гэнэ хэмээн үзэж, үүнийгээ хэрэглээнд оруулах арга замыг нь тодорхойлж өгчээ.

Бид урьд нь орчуулгын шүүмж хэмээн үздэг тэрхүү алив нэгэн орчуулгад хийсэн шүүмж бол дээрх хэрэглээний орчуулгазүйн орчуулгын шүүмж доторхи “санал шүүмж” нь юм. Тэгвэл орчуулгыг ариутган шүүх/хэвлэх үйл явц ба чанарын үнэлгээ гэдэг нь чухам юу вэ? Аливаа орчуулгыг хийсэн этгээдийн орчуулгын бүтээлийг

⁵ М.Амартайван, *Орчуулгын бүтээлийн номзүй*, Орчуулгазүй, МУИС, Улаанбаатар, No.05(452) 2016, 230-268-р тал.

⁶ Ш.Эгшиг, *Орчин үеийн орчуулгазүйн чиг хандлага хийгээд Монголын орчуулгазүй*, Орчуулгазүй, No.02, МУИС, ГХСС, Улаанбаатар, 2012, 4-р тал.

тухай тухайн улс дахь орчуулгын стандартын дагуу заавал ариутган шүүлгэж, тийн ариутгасны дараа хэвлэх эрх нь нээгддэг. Ариутган шүүсэн орчуулгын чанар нь ариутган шүүгээгүй орчуулгын бүтээл хэвлэхээс хавьгүй дээрдэх нь лавтай. Хэрэв орчуулгын алдаа мэдгээс болж цаашид үүсч болох элдэв асуудлыг орчуулагч дангаараа бус, хэвлэлийн газар үүрэлцэх тэр хариуцлага давхар үүсдэг.

Орчуулгын чанарын үнэлгээ гэдэг нь бас л нэлээд өргөн ойлголт бөгөөд энэ нь мэргэжлийн ба судалгааны гэсэн хоёр талтайгаар үнэлгээг хийж болохыг мөн зааж өгдөг. Алив мэргэжлийн сэдэвт орчуулгын бүтээлийг мэргэжилтнүүдийн зөвлөлөөр юм уу, тэр зөвлөлөөс томилогдсон этгээдээр хянуулах, шаардлагатай бол тэрхүү мэргэжлийн байгууллагын хяналт хийсэн болохыг баталгаажуулсны дараа орчуулгыг авч ашиглах эрх нь үүсэх ийм үйл явц өнөөгийн даяаршсан нийгэмд гарч ирж байгаатай холбоотой. Судалгааны чанарын үнэлгээ бол алив нэгэн орчуулгын бүтээлийг тодорхой зорилготойгоор судалж, түүнийг хэлшинжлэлийн, орчуулгазүйн болон тодорхой шинжлэлийн аргазүйгээр задлан шинжилж, уг бүтээлээр дамжуулан тэдгээр ухааныг өөрийг нь хөгжүүлэх, шинэ зүй тогтлыг нээх, судалгааны аргазүйг боловсруулах боломжийг олгож байдаг. Их дээд сургуулийн тодорхой ухааны чиглэлээр орчуулгын сэдэвт судалгааны ажлыг бүх төвшинд хийж байдаг билээ. Энэ нь өөрөө орчуулгын шүүмжид багтана гэсэн үг юм. Алив орчуулгын бүтээлийг судалсны дараа заавал дүгнэлт хийдэг, тэр дүгнэлт бол үндсэндээ тухайн орчуулгын бүтээлийн чанарын үнэлгээ болно. Сүүлийн үеийн гадаад хэлний салбарын ихэнх эрдэм шинжилгээний ажил орчуулгын судалгаанд тулгуурладаг, үүнийг хэлшинжлэлийн судалгаа хэмээн хэлж болох ч, орчуулгазүй хэмээх биеэ даасан хавсарга ухааны онол, аргазүйн дагуу л судалгааг хийж байгаа юм. Хэлшинжлэл бол суурь шинжлэх ухаан, энэ ухаанаас олон хэлний нөлөөлөлцлийн улмаас бүрэлдэж үүссэн орчуулгазүйн ухаан гарч ирсэн билээ. Зарим тохиолдолд хэлшинжлэлд нэг хэлний үүднээс тайлбарлахын аргагүй олон асуудалтай таардаг, олон хэлний нөлөөлөлцөл, нэвчилцлээс л мөн чанар нь тодордог олон үзэгдэл, ухагдахууныг орчуулгазүйн судалгаагаар илрүүлэн тайлбарлаж чаддаг юм. Орчуулгазүйн шинжлэх ухаан залуу шинжлэх ухаан, тиймээс уг шинжлэх ухааны гол гол нэр томьёо ухагдахуун нь өрнийн хэлүүдэд тодорхой болсон хэдий ч дэлхийн бусад хэсэгт тухайлбал, бидний оршин буй Азийн хэсэгт эдгээр нэр томьёог нутагшуулан оноох үйл явц яг хөгжлийн шатандаа явж байна. Хятадын их сургуулиуд, судалгааны хүрээлэнгүүдээс өнөө хэр нь баримталж байгаа нэг бодлого бол орчуулгазүйн онолын сурах бичиг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд зохиогдоогүй гэдгийг салбарын эрдэмтдийн зөвлөлөөс тогтоосон бол тэр чиглэлийн хичээл сургалтыг явуулахдаа англи хэл дээр байгаа барууны нэрт онолчдын сурах бичиг, онолын бүтээлийг ашиглахыг Хятадын Боловсролын хороо болон бусад төрийн байгууллагаас зөвшөөрч, Хятадын гадаад хэлний чиглэлийн нэр бүхий их сургуулиудыг тэрхүү гадны орчуулгазүйн нэрд гарсан бүтээлийг шууд англи хэлээр хэвлэх эрхийг олон улсын зохиогчийн эрхийн хууль журмын дагуу авч, бүтээлийг огтхон ч өөрчлөлгүйгээр өөрийн сургуулийн нэрээр хэвлэн ашиглахыг зөвшөөрч, сургалтын хөтөлбөрийг ч энэ дагуу боловсруулахыг нь чиглүүлж өгдөг юм. Энэ бол ихэвчлэн

ахисан төвшний сургалтын хөтөлбөрүүдэд хэрэгжиж байгаа сургалтын арга хэрэгсэл юм. Чингэхээр ийм хөтөлбөрөөр барууны шилдэг бүтээлийг эх хэлээр нь үзсэн хятадын орчуулгын судлалын бэлтгэгдсэн мэргэжилтнүүд тодорхой хугацааны дараа өөрсдөө онол, дадлагын сурах бичиг, бүтээлүүдээ гарган, шинжлэх ухааны нэр томъёог хятад хэлээрээ оноон гаргаж, цэгцлэн тогтоох нь лавтай.

Дээр өгүүлсэн өнгөрсөн хугацааны орчуулгын шүүмжийн талаархи тоон харьцуулалд гагц “санал шүүмж”-ийг тооцож гаргасан билээ. Орчуулгазүйн орчин үеийн хэрэглээний талыг илэрхийлэх ариутган шүүсэн талаархи редакторын үг, зөвлөмж, их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагад хийсэн орчуулгын судалгааны ажлыг нийтэд нь оруулж тооцвол дээр өгүүлсэн хувь хэмжээ ихээхэн өсөх нь мэдээж юм. Тэгэхээр бид шүүмж судлалд чухам юуг шалгуур болгохыг оновчтой болгох нь туйлаас чухал мэт санагдана.

Орчуулгын шүүмж гэдэг энэ ухагдахууныг бүрэн тодорхойлоход тийм амар биш, учир нь бид тухайн орчуулгыг сайн муу болсныг юугаар нь хэмжих вэ? Ямар ч орчуулагч орчуулга хийхдээ сайн орчуулга хийхсэн гэдэг. Гагцхүү орчуулагч бүр өөр өөр бие хүн байдаг тул орчуулга нь ч тус тусдаа ялгаатай болдог, үүнд тухайн хүний эх хэл ба гадаад хэлний мэдлэг чадвар хамгийн чухал хүчин зүйл болдог ч, тухайн хүний өссөн төрсөн орчин, хүмүүжил, ертөнцийг үзэх үзэл, орчуулга хийх тухайн үеийн нөхцөл байдал, уг орчуулгыг хийх болсон шалтгаан, зорилго гэх мэт тоймгүй олон хүчин зүйл нөлөөлдөг, тэр бүү хэл, цаг хугацаагаар шахсан захиалга сүүлийн үед түгээмэл болсон нь чанарт нөлөөлж л таарна. Тэгвэл чанарын шалгуур хийх хэм хэмжээг нь зааж өгч байж тухайн орчуулгыг хэмжиж чадахуйц болох нь гарцаагүй. Бид хэдэн жилийн өмнө орчуулгын ажлыг журамлах тухай асуудал дэвшүүлж, үүний нэг гарц бол орчуулгын үйлчилгээний стандартын асуудал хэмээн үзээд, энэ стандартыг үндэсний стандарт болгож авах ажлыг хийж гүйцэтгэсэн юм. Хэрэв үндэсний стандартын байгууллагаар батлагдсан стандартыг мөрдлөг болгодог дадал хэвшвэл, улсын хэмжээнд орчуулгын чанарын асуудал ихээхэн ахиж дээшлэх учиртай. Энэ нь орчуулгын шүүмж судлал тодорхой хэмжээнд хөгжиж байгаагийн нэг илрэл гэж үзэж ч болох юм.

Оросын эрдэмтэн Ю.П.Солодуб уран сайхны орчуулгын чанарыг үнэлэх хамгийн чухал шалгуур бол орчуулах эх ба орчуулга хоёрын уран сайхны хоорондын нийцэл⁷ гэдгийг онцолсон байдаг. Үүнтэй адил санааг орчуулгазүйч Ц.Магсар энэ сэтгүүлийн өмнөх дугаарт хэвлүүлсэн уран зохиолын орчуулгад тавих шаардлагын тухай өгүүлэлдээ тодорхой бичсэн байх агаад уран зохиолын орчуулгын чанарын хэмжээс болох зүйл нь чухамдаа “дүйцэл”, “нийцэл”⁸ хэмээн үзжээ.

⁷ Ю. П. Солодуб, Ф. Б. Альбрехт, А. Ю. Кузнецов Теория и практика художественного перевода. М., 2006, с.22

⁸ Ц.Магсар, *Уран зохиолын орчуулгад тавих шаардлага: “дүйцэл” ба “нийцэл” ойлголтуудын тухайд*, Орчуулгазүй, No.06(481), 2018, 38-44-р тал.

Орчуулгын шүүмж бол орчуулгын онол, практикийг хооронд нь холбож байдаг хэлхээс⁹ юм. Орчуулгын шүүмжээр дамжуулж орчуулагч чадамжаа байнга ахиулж байдаг бөгөөд шүүмж бол орчуулагчийг хөглөгч хийгээд хөдөлгөгч хүч. Орчуулагч шүүмжлэлээр дамжуулан, анзааргагүй хийсэн алдаагаа олж мэдэж болно. Тэгвэл энэ нь тэрхүү орчуулагчийн тухайн ухааны талаар илүү их мэдлэгтэй болох гэсэн эрмэлзэлтэй болгох ба үүнийхээ хүчинд илүү их зүйлийг уншиж судалж, оюун ухаанаа байнга зүлгэж суудаг хүн болгодог. Гадаад хэлээрх мэдэхгүй үг бүр нь орчуулагчийн хувьд үг төдий бус, мэдлэг болж тархинд нь шингэж байдаг. Магадгүй энэ шинэ мэдлэгээсээ орчуулах хэлэнд нь таарах үг байхгүй аваас шинэ үгийг гагцхүү орчуулагч хүн л эх хэлний үг бүтэх ёсны дагуу бүтээж чадна. Учир нь орчуулагч тэр ухагдахууныг одоохондоо бусдаас илүү ухааж ойлгосон байх бөгөөд тэрхүү тархинд нь бий болсон шинэхэн нялх хүүхэд лугаа адил ухагдахуунд нэр оноох хүндтэй эрх гагцхүү орчуулагчид тухайн цагт заяагдана. Хэрэв тэрбээр орчуулах ёстой цагтаа үг оноож (шинэ үг зохиож) өгч чадаагүй бол тэр эрх өөр хэн нэгэн мэдлэгтэнд шилжих нь дамжиггүй. Гэвч үүнийг нэр төртэй хийдэг хүн тэр бүр бас ховор байдаг. Учир нь Р.Гүрбазар судлаачийн тодорхойлсноор орчуулагч бол дүрийг дахин амилуулагч, анхны эх зохиолын санаагаар дахин цоо шинэ зохиол бүтээн туурвиж байгаа хүн. Энэ хүний эзэмшсэн орчуулах хэлний боловсрол мэдлэг ямар байхаас уг орчуулгын бүтээлийн амт үнэр өөрөө аяндаа уншигчдад ялгарч амтлагдаад эхэлдэг. Орчуулагч хүн эх зохиолыг тодорхой зорилготойгоор¹⁰ орчуулж байдаг. Чухам тэр зорилго нь юу гэдгээс шалтгаалж орчуулгын бүтээл нь өөрөө утга зохиолын өөр өөр төрөл жанрт хамаараад эхлэх юм. Утга зохиолын шүүмжийн аль төрөлд тэр орчуулгын бүтээл нь хамаарахаас шалтгаалж орчуулгын шүүмж нь тухайн төрөл жанрт холбогдох зохих шалгуураар шалгагдаж эхэлнэ. Үүн дээр давхар орчуулагчийн орчуулах гурван үндсэн чадвар нэмэгдэж “шалгуулах” болдог юм. Тэр нь манай “Мэргэд гарахын орон”-д заасан зарчмууд болох утга төгс мэдэхүйг хялбар байлгахын дээр их голын утгыг засалгүй орчуулах “нэрийтгэн найруулах”¹¹ зарчмыг хэлнэ. Орчуулагч хүн орчуулах эхийн их голын утгыг алдагдуулахгүй эх зохиолд үнэнч хандах, мэдэхүйеэ хялбар ойлгомжтой тодын зарчим, утга төгс илэрхийлэх яруу сайхан найруулгын зарчим эдгээрийг баримталж орчуулбал, орчуулагчид байвал зохих үндсэн чадварууд нь төгс илрэн гарах болно. Чингэхээр орчуулгын шүүмж бол утга зохиолын шүүмжийн шалгуур дээр орчуулагчийн ур чадварыг үнэлэх үнэлэмж нэмэгдэж шалгуулна гэсэн үг юм. Хариуцлага нь энгийн утга зохиолын шүүмжлэгчээс бараг хоёр дахин ихсэж байна.

⁹ Peter Newmark, *Translation Criticism, A Textbook of Translation*, Chapter 17, Shanghai Foreign Language Education Press, Prentice Hall, New York, London, Toronto, Sydney, Tokyo, 1988, p.184

¹⁰ Reiss, Katherina. “Text-types, Translation Types and Translation Assessment”. In Chesterman, Andrew. Ed. *Readings in Translation Theory*. Finland: Oy Finn Lectura. Ab. 1977.

Vermeer, Hans J. “Skopos and Commission in Translational Action”. In Chesterman. 1989.

Nord, Christiane. *Translating as a Purposeful Activity: Functionalist Approaches Explained*. Manchester: St. Jerome Publishing. 2007.

¹¹ Д.Дагвадорж, “Монголын гүн ухааны уламжлалт тогтсон таалал” (Мэргэд гарахын орон дээж бичгийн сурвалжаар), Алтан гадас одонт Улсын Багшийн Их сургууль, Улаанбаатар, 1994, 12-р тал.

Барууны орчуулгын онолч Петер Ньюмарк орчуулгын шүүмжийг хийхэд таван зүйлд төвлөрөх ёстой¹² гэж үзсэн байдаг.

1. Орчуулгын эхийн цаад санаа, зорилгыг тухайн сэдэвт хамаарах ухааных нь үүднээс шинжилж үзэх
2. Орчуулагчаас орчуулах эхийн санааг тайлсан байдал, орчуулгад хэрэглэсэн арга хийгээд орчуулга нь уншигчдыг татах эсэх асуудал
3. Орчуулах эх ба орчуулсан эх хоёрыг тодорхой хэсгүүдээр нь төлөөлүүлэн авч харьцуулах
4. Орчуулгыг үнэлэх
 - А. Орчуулагчийн үүднээс хийх үнэлгээ
 - Б. Шүүмжлэгчийн үүднээс хийх үнэлгээ
5. Орчуулсан хэлээр яригч үндэстний соёл хийгээд мэдлэгийн хувьд орчуулга нь зохистой байраа эзэлсэн эсэхийг үнэлэх эдгээр болно.

Петер Ньюмаркын дурдсан таван зүйлийн дотор гуравдахь нь хамгийн их түгээмэл байдаг ба шүүмжийн амин сүнс нь үүнд оршдог. Орчуулгын шүүмжийн дийлэнх нь орчуулах эх ба орчуулга хоёрыг харьцуулан үзэж асуудлыг дэвшүүлэн, энэ асуудлаа хэлзүй, үгзүйн төвшинд шинжлээд, хувилбарууд гаргаж ирж хэлэлцүүлдэг нь шүүмжийн сонгодог хэлбэр бөгөөд энэ ч аргаар өнгөрсөн зууны бараг бүхий л орчуулгын шүүмжийн ажил өрнөж, нийгэм олон нийтийг хамран орчуулгын чанарыг зохих хэмжээгээр дээшлүүлж байсан билээ.

Орчуулгын үнэлгээний шалгуурыг эрдэмтэд ерөнхий хэдэн маягаар тогтоожээ. Тухайлбал, АНУ-ын орчуулгазүйч Южин.А.Найда орчуулгын олон нийтийн харилцааны хандлагад илүү ихээр төвлөрөн, орчуулах эх ба орчуулга хоёрын хоорондын “идэвхт дүйцэл”-ийг тодорхойлон, орчуулгыг хүлээн авч буй уншигч ба сонсогчийн хариу ямар байх бол гэдэгт төвлөрч, орчуулах эхийн хэлээрх тухайн агуулгыг хүлээн авагч этгээд ямар хариу үйлдэл үзүүлсэн яг тэр хэмжээний хариу үйлдлийг орчуулсан хэлээр хүлээн авч буй этгээд үзүүлэхүйц байхад чиглэдэг. Сайн орчуулсан эсвэл хэлмэрчилсэн гэдгийн эцсийн шалгуур нь анхны хэлээрх эхтэйгээ орчуулга үнэн зөв таарах, амар ойлгохуйц байх, хэлбэрийн хувьд нийцтэй, уншигч ба сонсогчийн сэтгэлийг татахуйц байх явдал юм¹³. Чингээд Найда илүү нийцтэй орчуулга хэмээхүйн шалгуур нь дараахь гурван зүйлд төвлөрнө гэжээ.

- Харилцааны явц дахь орчуулгын нийтэд хүртээмжтэй үр өгөөж нь хэр байх
- Санааг ойлгох царааны хэмжээ нь ямар байх,
- Дүйцүүлэхдээ сайн муу дүйцүүлсний алин болох энэ гурав болно.

¹² Peter Newmark, *Translation Criticism, A Textbook of Translation*, Chapter 17, Shanghai Foreign Language Education Press, Prentice Hall, New York, London, Toronto, Sydney, Tokyo, 1988, p.186

¹³ Ш.Эгшиг “Монголын орчуулгазүйд Найдын онолыг идээшүүлэн хэрэглэх боломжийн тухай”, “Орчуулгын онол аргагүйн асуудалд: Орчин үе, чиг хандлага, онцлог” онол практикийн бага хурал, Орчуулах эрдэм 4(9), 2013 он, 6-20-р тал.

Германы орчуулгазүйч Ж.Хаусын “Орчуулгын чанарын үнэлгээний загвар”¹⁴ хэмээх түүний орчуулгазүйд оруулсан хамгийн чухал бүтээлд нь энэхүү орчуулгын шүүмж судлалд хамгийн ихээр холбогдох онолын ойлголтыг тусгасан юм. Түүний загвар нь мөн л Петер Ньюмаркын үзсэнчлэн, орчуулгын шүүмжийн амин сүнс болсон орчуулах эх ба орчуулсан эх хоёрын хоорондын харьцуулсан судалгаа ажээ. Энэ нь нийцэлгүй орчуулагдсан орчуулгын хэсэг ба алдаанд төвлөрдөг юм. Ж.Хаус үзэхдээ, орчуулгын чанарыг үнэлэх эхний алхам бол ямар төрөл жанрын утга зохиолын бүтээлд чанарын үнэлгээ хийх гэж байгаа болон тэр төрөл жанрт хамаарах бүтээлийн орчуулга хийх үеийн нөхцөл байдлыг сайтар тодорхойлж байж, дараагийн шатны үнэлгээ хийх байдал тодорч ирдэг гэсэн юм. Чингээд нийцэлгүй орчуулгын хэсэг ба алдаа нь далд шинжтэй байна уу, илэрхий тодорхой алдаа байна уу гэдгийг тогтоон, далд нууцлагдмал байгаа алдааг нь яагаад энэ алдаа гарах болсныг үгийн сангийн, өгүүлбэрзүйн, болон хам сэдвийн төвшинд үнэлэх хэрэгтэй, үүний зэрэгцээ орчуулагчийн уг орчуулгыг хийх үеийн нөхцөл байдлыг давхар тооцож явах ёстойг онцолсон үнэлгээний загвар юм.

1982 онд Вольфрам Вилсийн хийсэн орчуулгын шүүмж хийх хэм хэмжээг тогтоох гэсэн оролдлого ¹⁵ юм. Тэрээр орчуулах эх ба орчуулсан эх хоёрыг харьцуулахдаа нэг талаас нийцтэй, нийцгүй, алдаатай, эргэлзээтэй, засууштай гэсэн хэсгийг ялган авч тус бүрийг үгзүйн, өгүүлбэрзүйн болон хам сэдвийн төвшинд үнэлж байж эцсийн дүгнэлт хийх явдал бол орчуулгын шүүмжийн хэм хэмжээ болно гэж үзжээ. 1995 онд Кармен Валеро орчуулгын шүүмжийн цогц бүтцийг илэрхийлэн гаргасан юм. Тэрээр өмнөх судлаачдын орчуулгын шүүмж судлалд дэвшүүлсэн саналуудыг нэгтгэн, нэг цогц болгож чадсан бөгөөд хэрэв алив нэгэн орчуулгын бүтээлийг шүүмжлэх гэж байгаа л бол ийм цогц байдлаар авч үзэж байж, хамгийн бодит үнэлгээ гарахаар байгаа юм.

Кармен Валерогийн орчуулгын шүүмжийн цогц бүтэц¹⁶-ийг дараахь байдлаар илэрхийлж болох юм. Энэхүү бүтэц дөрвөн үндсэн хэсгээс тогтоно. Үндсэн хэсгүүд мөн дотооддоо задарч хуваагдаж байна.

1. Орчуулгын шүүмж бичих хэм хэмжээ
2. Дотоод төвшин
 - Эхийн төрөл
 - Эх ба орчуулгын анхны сэдэл
 - Эх ба орчуулгыг хүртэж буй хүний мэдлэгийн төвшин
3. Гадаад төвшин буюу орчуулга хийхэд оролцогчид
 - Орчуулга захиалагч ба орчуулагчийн үүрэг хандлагыг тогтоогч

¹⁴ Juliane House, *A Model for Translation Quality Assessment*. Tübingen: Narr.1977 Shabham Shakira, *Study of House's Model of Translation Quality Assessment on the Short Story and Its Translated Text*, Global Journal of Human-Social Science: (G) Linguistics & Education, Volume 14, Issue 3, Version 1.0, 2014, pp.9-10.

¹⁵ Wilss, W. *The science of translation*. Tübingen: Gunter Narr.1982

¹⁶ Carmen Valero, *Translation criticism as an independent area of study: Developing a framework for objective criticism*, *Livius*, 7 (1995) pp.201-212.

- Орчуулгын харьцуулал
 - Хэлний төвшинд боловсруулсан байдал
 - Орчуулагчийн мэдлэг ур чадварын байдлаас хамаарч хэрхэн орчуулагдсан байдал
5. Дээрх бүхэнд хийсэн үнэлгээ шүүмж

Кармен Валерогийн энэ бүтцийг нягтлан тунгаавал, нэгдэх хэсэг болох орчуулгын шүүмж хийх хэм хэмжээг В.Вилс тогтоосон, дотоод ба гадаад төвшний цаашид задарч ангилагдаж байгаа нь П.Ньюмарк, Ю.А.Найда, Ж.Хаус зэрэг бусад эрдэмтдийн дэвшүүлсэн санааг нэгтгэн тусгасан байх агаад, энэ бүхний эцэст дөрөв дэх хэсэг нь аяндаа тодорч, цогцоор нь үнэлэн дүгнэсэн шүүмжийг бичих боломж бүрдэнэ гэж үзжээ.

Дүгнэлт

Орчуулга байгаа цагт орчуулгын шүүмж байж л байдаг. Шүүмж сайн бол орчуулах үйл хэрэг сайжирна. Орчуулгын шүүмж хаа сайгүй гарсаар байна. Орчуулгын шүүмж судлал нь нийгмийн хөгжлийн байдлаас шалтгаалж далайц нь ихэсч, багасч байдаг. Өнөө үед хэл устай хүн олширч, өөрт аятай санагдсан зохиолыг монгол уншигчдад уншуулах юмсан гэж орчуулдаг хүн бий. Мэргэжлийн чиглэлийн болон дэлхийн сонгодог, эсвэл, алдартай бүтээлүүдийг орчуулах явдал бол дэлхий нийтийн хандлага билээ. Мөн гадаадын зарим улсын соёлын зөөлөн хүчний бодлогоор орчуулгын ажлыг дэмжих явдал ч бас бий. Ийнхүү манай оронд тоймгүй их орчуулгын бүтээл шил шилээ даган гарч байна. Манай уншигчид ч бас их сайн уншигч түмэн тул шинэ болгоныг хурдан хүртдэг, тэгээд өнөөгийн мэдээлэлжсэн нийгэмд өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлцгээж байна¹⁷. Мөн их, дээд сургуулийн гадаад хэлний салбарын суралцагчдын хийсэн бакалаврын төгсөлтийн ажил, магистр, докторын зэрэг горилсон ажил бүрт шүүмжлэгч томилж, шүүмж бичүүлж хэлэлцүүлдэг. Орчуулгын судалгаа шинжилгээ бүхэн тэр чигээрээ орчуулгын шүүмж, санал шүүмжид хамаарна. Эдгээр олон төрлийн шүүмжийн чиглэл тус бүрээр нь судалгаа хийх боломжтой. Орчуулгын шүүмж судлалын оногдохуун нь орчуулах эх, орчуулсан эх, орчуулга захиалагч, орчуулагч, эхийн уншигч, орчуулгын уншигч гээд орчуулгын чанарт нөлөөлөх бүхэн байна. Орчуулгын шүүмжийг хэрхэн судлах арга замыг тодорхойлох нь чухал бөгөөд хэрвээ үүнийг тодорхойлоход хүндрэлтэй бол, түүх уламжлалаасаа хайж болно, мөн дэлхийн тэргүүний судлаачдын бүтээлийг сайн үзэж судлах хэрэгтэй. Өнөө цагт орчуулгын шүүмж нь ихдээд орчуулгын шүүмж судлал нь орхигдох хандлагатай байна. Бид шүүмжийг явцуу ойлгодог ойлголтоо засаж, өргөн хүрээнд сэтгэх ёстойг дээр өгүүлсэн гадаадын орчуулгазүйчдийн онол үзлээс бэлхэнээ мэдэж болно.

¹⁷ Б.Шижирбаатар, Орчуулгын шүүмж: Жан Жак Руссогийн “Нийгмийн гэрээ” <https://www.reader.mn/posts/view/49/>

Б.Пунцагдулам одон орон, физик сурдаг оюутан Баабарыг шүүмжилжээ. <https://prezi.com/cvs7igofyqb9/presentation/>

Abstract

The purpose of this article is to present that, translation criticism belongs to both literature criticism and translation studies. And thus it can be viewed as a multiplex criticism. It is an essential link between translation theory and its practice. The work aims to introduce translation criticism appropriated to the criteria and method developed by the translation scholars like Peter Newmark, Juliane House, Eugene A Nida, Carmen Valero-Garces and so on. In their modern works, we need to understand the broader perspective of translation criticism rather than our own parochial critiques.

Номзүй

1. Буяннэмэх.С, (1968) Түүвэр зохиол, Улаанбаатар
2. Билигсайхан.Ч, Цэнд.Д (1983) Уран чадварын нууц, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар
3. Галбаатар.Д, (2012) Уранзохиол: Онол, түүх, шүүмжлэл: Нэвтэрхий толь, Улаанбаатар
4. Дагвадорж.Д, (1994) “Монголын гүн ухааны уламжлалт тогтсон таалал” (Мэргэд гарахын орон дээж бичгийн сурвалжаар), Алтан гадас одонт Улсын Багшийн Их сургууль, Улаанбаатар
5. Дагвадорж.Ч, (1989), Уран сайхны шүүмжлэлийн тухай, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар
6. Магсар.Ц, (2009) ХХ зууны Монголын утга зохиолын шүүмжлэл, Бит пресс, Улаанбаатар
7. Магсар.Ц, (2018) Уран зохиолын орчуулгад тавих шаардлага: “дүйцэл” ба “нийцэл” ойлголтуудын тухайд, Орчуулгазүй, No.06(481)
8. Мөнх.Ц, (1980) Цаг үе утга зохиол шүүмжлэл, УХГ, Улаанбаатар
9. Утга зохиолын шүүмжлэл (1985) Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар
10. Ц.Хасбаатар, С.Дулам, (1981) Уран зохиолын онолын үүд, Улаанбаатар
11. Ш.Эгшиг (2013) “Монголын орчуулгазүйд Найддын онолыг идээшүүлэн хэрэглэх боломжийн тухай”, “Орчуулгын онол аргазүйн асуудалд: Орчин үе, чиг хандлага, онцлог” онол практикийн бага хурал, Орчуулах эрдэм 4(9)
12. Ш.Эгшиг, (2013) Орчин үеийн орчуулгазүйн чиг хандлага хийгээд Монголын орчуулгазүй, Орчуулгазүй, No.02, МУИС, ГХСС, Улаанбаатар
13. Солодуб, Ф. Б. Альбрехт, А. Ю. Кузнецов (2006) Теория и практика художественного перевода. Москва.,
14. Carmen Valero, (1995) *Translation criticism as an independent area of study: Developing a framework for objective criticism*, Livius 7, Madrid
15. Juliane House, (1977) *A Model for Translation Quality Assessment*. Tübingen: Narr.
16. Nord, Christiane. (2007) *Translating as a Purposeful Activity: Functionalist Approaches Explained*. Manchester: St. Jerome Publishing.

17. Peter Newmark, (1988) *Translation Criticism, A Textbook of Translation*, Chapter 17, Shanghai Foreign Language Education Press, Prentice Hall, New York, London, Toronto, Sydney, Tokyo
18. Reiss, Katherina. (1977) “Text-types, Translation Types and Translation Assessment”. In Chesterman, Andrew. Ed. *Readings in Translation Theory*. Finland: Oy Finn Lectura.Ab.
19. Shabham Shakira, (2014) *Study of House’s Model of Translation Quality Assessment on the Short Story and Its Tarnslated Text*, Global Journal of Human-Social Science: (G) Linguistics & Education, Volume 14, Issue 3, Version 1.0.
20. Vermeer, Hans J. (1989) “Skopos and Commission in Translational Action”. In Chesterman.
21. Wilss, W. (1982) *The science of translation*. Tübingen: Gunter Narr.